

## **“Нако түлш” ХК-ийн 2016 оны үйл ажиллагааны тайлан**

Компанийн нэр: ”Нако түлш” ХК

Хаяг: Дархан-Уул аймаг, Дархан сум, Үйлдвэрийн хотхон 13-р баг

Утас:70379006

Улсын бүртгэлийн дугаар:	1910001019
Регистрын дугаар:	4489969
Үйл ажиллагааны чиглэл:	Хагас коксон утаагүй түлшний үйлдвэрлэл
Хувьцаа эзэмшигчдийн тоо:	126 хувьцаа эзэмшигчид 12,615,721 ширхэг хувьцаа эзэмшиж байна /2016.03.18-ны байдлаар/

### **Үйл ажиллагааны тайлан:**

“Нако түлш” ХК 2016 онд дараахи ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Нийт 8118,5 тн нүүрс хүлээн авч 5841,2 тн нүүрс боловсруулан 3730,3 тн хагас кокс үйлдвэрлэж, коксын гарц 64%-тай байв. /Нийт хүлээн авсан нүүрсний 28% нь нүүрсний чулуу(11%), 30мм-ээс доош бүхэллэгтэй зууханд орох боломжгүй нунтаг нүүрс(15%), халаалтын хэрэгцээнд зориулсан нүүрс(2%)
- Бүхэллэг хагас кокс борлуулах гэрээг Орхон аймгийн ЗДТГ-тай байгуулж 434,85 тонн хагас кокс болон нунтаг нүүрс, Дархан-Уул аймгийн Дархан сумын 15-р багийн гэр хорооллын айл өрхүүдэд 521,65 тонн хагас кокс, ДДЦС-д 647,82 тонн нунтаг хагас кокс борлуулсан байна.
- Мөн “Таван нуур” ХХК-д 148,28 тн нунтаг нүүрс, “Дархан Мөнхийн илч” ХХК-д 459,12 тн нунтаг хагас кокс, “ЭМТ Наран” ОНӨҮГ-д 598,16 тонн нунтаг хагас кокс, “Бүрэн Дулаан” ХХК-д 1206,73 тонн, “Бүрэн Дулаан Бугант” ХХК-д 839,71 тонн нунтаг хагас кокс, “Бурхантын Илч” ХХК-д 97,72 тонн нунтаг хагас кокс борлуулсан байна.
- Зуухнаас гарсан коксын конвейерын дээд хэсгийг битүүмжилж, агааржуулалтын хоолойгоор уурыг дээш гаргаснаар зуухны агаар өгөлтийн вентиляторын хөдөлгүүрт сөрөг нөлөө үзүүлдэг байсныг үгүй болгосон, мөн коксоос ялгарсан эхүүн үнэрийг бүрэн гадагшлуулдаг болсон.
- Үйлдвэрийн барилгын дотор талд халаалтын регистерүүд суурилуулснаар коксын тос, хөргөлтийн усны хоолой, хаалт хөлдөж хагарах байдал үгүй болсон.
- Зуухны доод хэсгийн кокс гарах амны хийцийн хэсгийг өөрчилснөөр шланкдах байдал эрс багасаж, нүүрс буулт жигд болсон.
- Зуух ачааллах бункерийн гидро хаалтны хоёр талд мэдрэгч тавьж өгснөөр хаалт эвдрэх эрсдэлийг багасгаж өгсөн.
- Үйлдвэрийн дотор талын элеватор тэжээгч конвейер болон гадна талбайд байрлах коксын конвейеруудад давтамж хувиргагч (инвертор) шинээр суурилуулсан.
- Нүүрс хүлээн авах болон коксын конвейерын толгойд вибератортой шигшүүр суурилуулсан.
- Хоёр зуухны галын хотлын мэдрэгчээс дээш 1.6 метрийн зайд нэмэлт дулаан мэдрэгч, мөн сэтгүүр суурилуулсан.

- Гүний худгаас халаалтын зуухны барилга хүртэлх хүйтэн усны шугам хоолойг халдаг кабелаар оросноор хөлдөлт үүсдэг байсныг үгүй болгосон.
- Үйлдвэрийн барилгын дотор гэрэлтүүлгийг хүчин чадлыг нэмэгдүүлж LED гэрэл суурилуулснаар ажиллах орчныг сайжруулсан.
- Захиргааны барилгын хана, таазыг зориулалтын дулаалгын материалаар дулаалснаар дулаан алдагдлыг багасгасан.
- Шатдаг хий болон нүүрсээр ажилладаг үйлдвэрийн барилгын халаалтын зуухыг шинээр, захиргааны барилгын халаалтын зуухыг шинэчилж солих ажлыг хийсэн.
- Зуухны хөргөлтийн усан сангийн хананы ус нэвчилтийг зогсоож, хоёр насосыг хүйтний улиралд хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлж дулаалах ажлыг хийсэн.

**Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд:**

Тус компани нь 2016 оны 12-р сарын 31-ны өдрөөр дуусгавар болгон санхүү байдлын тайлан, орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан тэнцлээ Олон улсын стандарт болон Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн хууль түүнд нийцүүлэн гаргасан журам, заавар, аргачлалаар мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу гарган санхүү, татварын байгууллага болон холбогдох бусад газруудад тушаасан. Хараат бус аудитын итгэмжлэгдсэн байгууллага “Далайван аудит” ХХК-иар хянуулан баталгаажуулсан.

Компанийн 2015, 2016 оны жилийн орлогын тайлангийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

Үзүүлэлт	2015 он	2016 он
Борлуулалт	34 584,5	281 743,4
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	88 058,4	905 717,2
Нийт ашиг	-53 473,9	-623 973,8
Үйл ажиллагааны бус орлого	228,5	108,6
Үйл ажиллагааны зардал	565 067,5	709 280
Үйл ажиллагааны бус зардал	398,5	2 135,8
Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал	-618 711,4	-1 335 281,0
Орлогын татварын зардал	114,6	
Цэвэр ашиг,алдагдал	-618 826,0	-1 335 281,0

Борлуулалт 2015 онд өмнөх онтой харьцуулахад 247 158,9 мянган төгрөгөөр өссөн байна. Мөн үйл ажиллагааны бусад зардалд “Шарын гол” ХК болон ЕСБХБанкны зээлээс 476 456,7 мянган төгрөгийн санхүүжилт хийгдсэн.

Цалин хөлсний зардалд 391 691,1 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 83 383,4 мянган төгрөг, ашиглалтын зардалд 40 622,2 мянган төгрөг, түлш шатахуун, тээврийн хөлс сэлбэг хэрэгслийн зардалд 41 821,1 мянган төгрөг, ХХОАТ 16 557,2 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Компанийн 2015 он, 2016 оны хөрөнгө, эх үүсвэрийн тэнцлийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

Хөрөнгө өр төлбөрийн үзүүлэлтүүд	2015 он	2016 он
Эргэлтийн хөрөнгө	933 459,1	967 589,8
Эргэлтийн бус хөрөнгө	2 845 046,4	2 754 926,5
Нийт хөрөнгийн дүн	3 778 505,5	3 722 516,2
Богино хугацаат өр төлбөр	1 874 329,7	3 178 235,1
Урт хугацаат өр төлбөр	778 528,1	753 914,4
Эзэмшигчийн өмчийн дүн	1 125 647,8	-2 09 633,3
Өр төлбөр, эзэмшигчийн өмчийн дүн	3 778 505,5	3 722 516,2

Ноогдол ашгийн талаарх мэдээлэл:

Компани 2016 онд алдагдалтай ажилласан тул ноогдол ашиг тараагаагүй болно.

Үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигчдийн болон ТУЗ-ийн мэдээлэл:

Компани их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй. Компанийн хяналтын багц эзэмшигчдийн хувьд өөрчлөлт ороогүй.

Компанийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл

№	Овог нэр	Албан тушаал	Хувьцааны хувь
1	Шарын Гол ХК	Нүүрс олборлолт	92,93%

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Б.Батбаатар, Жэймс Пассин, Ж.Баясгалан, Ж.Эрдэмбилэг, Д.Даянбилгүүн, Б.Лхагвадорж, хараат бус гишүүдээр Д.Нарангоо, Б.Мянганбаяр, Д.Түвшинтөгс нар ажиллаж байна.

Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны танилцуулга:

№	Овог нэр	Албан тушаал	Эрхэлж буй ажил	Боловсрол
1	Б.Батбаатар	ТУЗ-ийн дарга, ердийн гишүүн	Шарын гол ХК-ийн гүйцэтгэх захирал	Дээд
2	Жэймс Пассин	Ердийн гишүүн	Шарын гол ХК-ийн ТУЗ-ийн гишүүн	Дээд
3	Ж.Баясгалан	Ердийн гишүүн	Нако Түлш ХК-ийн гүйцэтгэх захирал	Дээд
4	Ж.Эрдэмбилэг	Ердийн гишүүн	СВМ ХХК-ийн гүйцэтгэх захирал	Дээд
5	Д.Даянбилгүүн	Ердийн гишүүн	БиДиСек ХК-ийн гүйцэтгэх захирал	Дээд
6	Б.Лхагвадорж	Ердийн гишүүн	БиДиСек ХК-ийн тэргүүн дэд захирал	Дээд
7	Д.Нарангоо	Хараат бус гишүүн	Үнэмлэхүй эрх ХХК-ийн гүйцэтгэх захирал	Дээд
8	Б.Мянганбаяр	Хараат бус гишүүн	СВМ ХХК ажилтан	Дээд

9	Д.Түвшинтөгс	Хараат бус гишүүн	МУИС, Монгол хэл соёлын сургууль, багш	Дээд
10	Ж.Энхцэцэг	ТУЗ-ийн нарийн бичиг	Нако Түлш ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичиг	Дээд

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нар 100 хувь компанийн засаглалын сургалтанд хамрагдсан.

“Нако Түлш” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал **2016 оны 04 сарын 22-ны** өдөр хуралдаж компанийн ТУЗ-ийн гишүүдийн томилох, 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан батлах, 2016 оны бизнес төлөвлөгөө батлах, 2016 оны ТУЗ-ын төсөв батлах зэрэг асуудлаар хэлэлцсэн юм. Уг хуралд нийт саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдийн 92,93 хувь санал ирүүлсэн бөгөөд хэлэлцэж буй асуудалтай холбогдож гаргасан хурлын шийдвэрийг 100 хувийн саналаар баталсан байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгосон бөгөөд **2016 оны 05 сарын 23-ны өдөр** Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулан ТУЗ-ийн дэргэдэх хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон.

А. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын дэд хороог Б.Мянганбаяр, Д.Даянбилгүүн, Д.Нарангоо гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус Б.Мянганбаяр гишүүнийг томилсон.

Б. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын дэд хороог Б.Лхагвадорж, Б.Мянганбаяр, Д.Түвшинтөгс гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Цалин урамшууллын дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Б.Лхагвадорж -г томилсон.

В. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх дэд хороог Ж.Эрдэмбилэг, Д.Түвшинтөгс, Д.Нарангоо гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Нэр дэвшүүлэх дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Ж.Эрдэмбилэгийг томилсон.

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2016 онд гишүүдийн орон зайгаас шалтгаалан ТУЗ-ийн хурлыг онлайн болон гишүүд оролцсон хоёр хэлбэрээр хийж байсан. Дээрхи хугацаанд нийт 4 удаа хуралдаж 8 тогтоол батлагдаж гарсан.

- Ногдол ашиг хувиарлах эсэх тухай, аудитлагдсан тайлангийн тухай зэрэг компанийн санхүү эдийн засагтай холбоотой 2 асуудал.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах, аудитын байгууллага сонгох, ТУЗ-ын дарга, ТУЗ-ын нарийн бичиг, Гүйцэтгэх захирал томилох, ТУЗ-ын аудитын хороо, нэр дэвшүүлэх хороо болон цалин урамшууллын хороо сонгох тухай компанийн удирдлага зохион байгуулалтын чиглэлээр 5 асуудал хэлэлцэж шийдвэр гаргаж байсан.
- Тайлант жилд их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй.

“Нако Түлш” ХК **2015 оны 04 сарын 16**-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулж дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2015 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2015 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

“Нако Түлш” ХК **2014 оны 04 сарын 22**-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулж дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2013 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2014 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2014 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах